



ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 1/30

Чингис хот

Өндөрхaan уулын тахилгын ёслол зохион байгуулах
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Жил бүрийн зуны эхэн сарын шинийн 3-ны өдөр уламжлал болгон зохион байгуулдаг Өндөрхaan уулын тахилгын ёслол зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн
ахлагч:

Ж.Гантулга

-Төрийн Захиргааны удирдлагын
хэлтсийн дарга

Гишүүдэд:

Т.Баяржаргал

-Хэнтий нийтлэг үйлчилгээ ОНӨҮГ-ын
Захирал

Б.Дархантөр

-Байгаль орчин, аялал жуулчлалын
газрын дарга

Б.Хашмаргад

-Хан Хэнтийн дархан цаазат газрын
хамгаалалтын захиргааны дарга

Ч.Сарантуяа

-Хэрлэн сумын Мал эмнэлэг үргжлийн
тасгийн дарга

Н.Хатанбаатар

-Мөрөн сумын Засаг даргын орлогч

О.Гомбобаатар

-Өндөрхaan тохижилтын газрын захирал

Х.Төмөрбаатар

-Цагдаагийн газрын нийтийн хэв журмын
ажил хариуцсан ахлах байцаагч,
цагдаагийн хошууч

Ж.Эрдэнэбат

-Онцгой байдлын газрын орлогч,
Урьдчилан сэргийлэх тасгийн дарга

Б.Батболд

-Шадавдаржаалин хийдийн Да лам
/зөвшилцсөнөөр/

Ш.Дамбажамц

-Гүндүгаварлин хийдийн Хамба лам
/зөвшилцсөнөөр/

Нарийн бичгийн
дарга:

Д.Ганболд

-Төрийн Захиргааны удирдлагын
хэлтсийн ахлах мэргэжилтэн

2. Тахилгын үйл ажиллагааны бэлтгэл ажлыг сайтар хангуулах, уламжлалт ёс заншлыг хадгалах, нийгмийн хэв журмыг сахиулахад онцгой анхаарч ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Ж.Гантулга/-д даалгасугай.

ДАРГА

Ж.ГАНБААТАР